



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

\*Е/өдөр

яугаар <sup>^</sup>-<sup>^</sup>/<sup>^</sup>

Сүхбаатар сум

“

2025.07.18

№ СХШ/2025-ӨГ-01

Сэлэнгэ аймаг

Иргэн Э.Энхчимэгийн гаргасан гомдлын дагуу хийсэн хяналт  
шалгалтын дүнгийн тухай

**Нэг: Хяналт шалгалтын үндэслэл, зорилго**

1.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1, 5.2.5 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг тус тус үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, Т.Одсүрэнгийн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталсан хяналт шалгалт хийх СХШ/2025-ӨГ-01 удирдамжаар Авлигатай тэмцэх газраас 2025 оны 06 сарын 10 ны өдөр ирүүлсэн 05/10546 дугаартай албан тоотыг үндэслэн Сэлэнгэ амгийн Сант сумын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан зарим иргэдийн төлөлттэй холбоотой асуудлаар харьяаллын дагуу иргэний өргөдөлд тусгасан асуудлаар хяналт шалгалтыг гүйцэтгэж дүгнэлт гаргах зорилготой.

1.3. Сэлэнгэ аймгийн Сант сумын Хүнс жижиг дунд үйлдвэрлэл. Хоршоо хариуцсан мэргэжилтэн Э.Энхчимэг нь Авлигатай тэмцэх газарт Сэлэнгэ аймгийн Сант сумын хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зарим зээлийн гэрээний график, ХХС-ын зээлийн программд бүртгэж оруулсан графикаас өөр зөрүүтэй, хугацаа хэтэрсэн зээлдэгчид алданги тооцоогүй, мөн зээл авсан иргэний барьцаанд тухайн зээлийг судлаж олгосон мэргэжилтний үл хөдлөх хөрөнгө барьцаалсан байсан, зээл авсан иргэд тухайн төслөө хэрэгжүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан зэрэг асуудлыг шалгуулах хүсэлт гаргасан байна.

1.4. Дээрх дурдсан гомдолтой асуудлуудын дагуу хяналт шалгалтыг дараах асуудлын хүрээнд шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд.

- Зээлийн гэрээний график, ХХС-ын зээлийн программд бүртгэж оруулсан графикаас өөр зөрүүтэй талаар

- Зээл авсан иргэний барьцаанд тухайн зээлийг судлаж олгосон мэргэжилтний үл хөдлөх хөрөнгө барьцаалуулсан талаар
- Хугацаа хэтэрсэн зээлдэгчид алданги тооцоогүй талаар
- Зээл авсан иргэд тухайн төслөө хэрэгжүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан талаар

1.5. Шалгалтад Сэлэнгэ аймгийн Сант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар Хүнс жижиг дунд үйлдвэрлэл. Хоршоо хариуцсан мэргэжилтэн Э.Энхчимэг болон нягтлан бодогч Мөнхзаяа болон зээл авсан иргэн М.Бадамхорол нараас нэмэлт тайлбар тодруулга авч холбогдох баримтуудыг хамруулав.

### **Хоёр: Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал, шалгуулагчийн санал хүсэлт**

#### **2.1 Зээлийн гэрээний график, ХХС-ын зээлийн программд бүртгэж оруулсан графикаас өөр зөрүүтэй оруулсан асуудлын талаар:**

Мэргэжилтэн Э.Энхчимэг нь С.Оюунбаярын зээлийг алданги бодуулахгүй хугацаа хэтрэлт гаргахгүйн тулд өмнөх мэргэжилтэн Ж.Оюунбат зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг өөрчилж зээлийн программд оруулсан байсныг би 2024 оны 10 сард анх байгуулагдсан зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтийн хуваарийг засаж оруулсан. Энэ талаар тайлбар, нотлох баримтыг Хөтөлийн цагдаагийн газрын байцаагчид өгч, эргэн холбогдохоор 12-15 удаа (гар утас уруу) залгахад утсаа аваагүй өнөөдрийг хүрсэн гэсэн тайлбар өглөө.

Дээрх асуудлын дагуу тулган баталгаажуулахад С.Оюунбаярын зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарь нь гэрээний нөхцөлтэйгээ нийцэж байв.

Иргэн С.Оюунбаяр нь 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Барилгын материалын худалдаа” төслөөр 20,0 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр авсан. Гэвч тухайн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй бөгөөд барилгын материалын худалдаа эрхлэхийн оронд хүнсний болон өргөн хэрэглээний барааны дэлгүүр ажиллуулсан байна.

КОВИД-19 цар тахлын улмаас дэлгүүр ажиллуулах боломжгүй болсон гэсэн шалтгаанаар зээлийн эргэн төлөлтийг гэрээний хуваарийн дагуу бүрэн хийлгүй, хугацаа хоцроосон. Үүний улмаас 2025 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар төлөх ёстой үлдэгдэл нь 8,600.0 мянган төгрөг байх ёстой атал бодитоор 16,379.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, ийнхүү 7,563.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байна.

#### **2.2 Зээл авсан иргэний барьцаанд тухайн зээлийг судлаж олгосон мэргэжилтний үл хөдлөх хөрөнгө барьцаалуулсан талаар**

Мэргэжилтэн Э.Энхчимэгийн мэдээлснээр, иргэн Ц.Тогтохын зээлд өмнөх мэргэжилтэн Ж.Оюунбат үл хөдлөх хөрөнгөө барьцаалуулсан тухай тайлбар өгсөн байна.

**Тулган баталгаажуулахад:** Ц.Тогтох нь 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр “Хаягдал түүхий эд авах цэг байгуулах” төслөөр 5,000.0 мянган төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр авчээ. Энэ үед мэргэжилтэнээр ажиллаж байсан Ж.Оюунбатын Ү-1311000096 дугаартай 66.7 м<sup>2</sup> хувийн сууцыг барьцаанд тавьсан бөгөөд барьцаанд тавих тухай итгэмжлэл хийлгэж наториатаар баталгаажуулсан байна.

Уг барьцаа нь хууль, журам зөрчсөн, эсвэл буруутай гэж үзэх үндэслэл байхгүй бөгөөд зээл нь бүрэн хаагдсан байна.

## **2.3 Хугацаа хэтэрсэн зээлдэгчид алданги тооцоогүй талаар**

Мэргэжилтэн Э.Энхчимэг нь иргэн Б.Цэвээнжавын зээлд алданги тооцоогүй байсныг би алданги нөхөж бодуулсан гэсэн гомдол гаргасан.

**Тулган баталгаажуулахад:** Б.Цэвээнжав нь 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр “Цагаан идээ боловсруулах” төслөөр 15,000.0 мянган төгрөгийн зээл авч, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд төлбөрөө бүрэн хийлгүй, хугацаа хэтэрсэн бөгөөд өмнөх мэргэжилтэн зээлийн алдангийг бүрэн тооцоогүй байсан байна.

Харин мэргэжилтэн Э.Энхчимэг зээлийн алдангийг нөхөн тооцож, 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зээлийг бүрэн хаалгуулсан болох нь тогтоогдсон.

## **2.4 Зээл авсан иргэд тухайн төслөө хэрэгжүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан талаар**

Зээл авсан иргэдийн зээлийн ашиглалт, төслийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

- Б.Цэвээнжав нь 2019 онд “Цагаан идээ боловсруулах” төслөөр 15,000.0 мянган төгрөгийн зээл авч, төслийг хэрэгжүүлэлгүй зээлээ хаасан байна.
- Ц.Тогтох нь 2019 онд “Хаягдал түүхий эд авах цэг байгуулах” төслөөр 5,000.0 мянган төгрөгийн зээл авч, төслийг хэрэгжүүлэлгүй зээлээ хаасан байна.
- “Буян тээг” ХХК нь 2019 онд “Үйлдвэрлэл, үйлчилгээний байр засварлах” төслөөр 10,000.0 мянган төгрөгийн зээл авч, төслийг хэрэгжүүлэлгүй зээлээ хаасан байна.
- С.Оюунбаяр нь 2023 онд “Барилгын материалын худалдаа эрхлэх” төслөөр зээл авсан боловч өнөөг хүртэл төслийг хэрэгжүүлээгүй байна. Гэсэн хэдий ч шалгалтын явцад энэ ондоо багтаан зориулалтын дагуу барилгын материалын худалдааг эхлүүлнэ гэсэн хариуг бичгээр гарган ирүүлсэн.

## **Гурав. Дүгнэлт, шийдвэрлэлт, санал хүсэлт, зөвлөмж**

### **3.1 Дүгнэлт:**

3.1.1 Хяналт шалгалтын дүнд зарим иргэн авсан зээлээ зээлийг

зориулалтын бусаар ашигласан, төслийг хэрэгжүүлээгүй, зээлийн гэрээний график болон зээлийн программын зөрүү, үлдэгдэл гарсан нь тогтоогдлоо. Мөн өмнөх мэргэжилтнүүдийн буруутай үйл ажиллагаанаас хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцоогүй, мэргэжилтний үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавьсан зэрэг зөрчил дутагдал гарсан байна. Иймд цаашид зээлийн хяналт, зориулалтын ашиглалтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв. улмаас дээрх зөрчил дутагдал

3.1.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийн хүрээнд Б.Цэвээнжав, Ц.Тогтох болон “Буян тээг” ХХК нь төслийн зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй боловч авсан зээлээ бүрэн хаасан байна.

### **3.2 Шийдвэрлэлт:**

**3.2.1.** Зээлдэгчийн зээлийн баталгаанд тухайн зээлийг шийдвэрлэсэн мэргэжилтний үл хөдлөх хөрөнгө орсон нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.2-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй”

3.2.2. Зээлийн гэрээний дагуу хугацаа хэтэрсэн үлдэгдэлд алданги тооцоогүй зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...”, ХХААС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.6-д “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол зээлийн үлдэгдлээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги ногдуулах ба алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд заавал тусгана”,

**3.2.3.** Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавиагүйгээс иргэд болон аж ахуйн нэгжүүд авсан зээлээ гэрээнд заасан төслийн зориулалтаар ашиглаагүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д хариуцлагатай байх, ...”, ХХААС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.4-д “Зээл авсан аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан, дансны мэдээллийг гаргуулан авах” 7.4.2-т “Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад хүргүүлнэ”; 7.4.3-т “Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын

хэрэгжилт хариуцсан байгууллагын хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх”, 11.1-д “Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй”

### 3.3 Санал хүсэлт

- Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд цаашид хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах зорилгоор мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах.
- Зээл олголт, хэрэгжилтийн явцыг тогтмол үнэлж, хугацаанд төлөлтийг баталгаажуулах хяналтын давтамжийг мөрдүүлэх.

### 3.4 Зөвлөмж

- Зээлийн гэрээ, хуваарийн бүртгэлийг цахим системд бүрэн хөтөлж, өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох баримтаар нотлуулж баталгаажуулдаг байх.
- Зээлдэгчдийн төслийн хэрэгжилтийг газар дээр нь тогтмол шалгаж, зориулалтын бусаар ашигласан тохиолдолд хууль, журмын дагуу арга хэмжээ авах хяналтын зөвлөлийн ажлыг сайжруулах.
- Давтан зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод хяналтын тогтолцоог чангатгах, тайлагналтыг ил тод болгох.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ